



МАСКАА ЗҮҮЕ



ГАРАА УГААЯ



ЗАЙГАА БАРЬЯ



УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (07)

2021.02.15

БХБ-ЫН САЙД Б.МӨНХБААТАР САЛБАРЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД, ҮЙЛДВЭРЧНИЙ БАЙГУУЛЛАГУУДАЙ ГУРВАН ТАЛТ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭРТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



БХБ-ын сайд Б.Мөнхбаатар 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-ын ерөнхийлөгч М.Батбаатар, “Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо” ТББ-ын дарга Б.Батцогт нартай Барилгын салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээр, “Монголын Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо” ТББ-ын тэргүүн Ж.Батсуурь, “Монголын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо” ТББ-ын дарга Б.Жавзандулам нартай Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээр байгууллаа. Хэлэлцээрийн хүрээнд талууд олон ажлыг хамтран хийж хэрэгжүүлэхээр тусгасны дунд усны үнэ, тарифийг нэмэгдүүлэх, цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах болон нийтийн аж ахуйн салбарын үйлчилгээг үзүүлэхэд зарцуулж буй бодит өртгийг тооцон, хөдөлмөрийн бүтээмжийг шударгаар үнэлэх, ОСНАА-н байгууллагуудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхийг сайжруулах, техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ажилчдыг орон сууцны төсөл хөтөлбөрт хамруулах зэрэг ажил багтжээ.

Эх сурвалж: БХБЯ

Ж.ДАГВАСҮРЭН: ШУГАМ, ХООЛОЙГ СҮВЭГЧЛЭН ДОТРОЛОХ ТЕХНОЛОГИ НЭВТЭРЛЭЭ




“...Дулааны шугам сүлжээ үүсээд 60 жил, Ус сувгийн удирдах газар 62 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Шугам сүлжээний насжилт өндөр болсон тул тогтмол засвар үйлчилгээ хийх шаардлага тулгарч, жил бүр шаардлагатай засвар үйлчилгээг төлөвлөн хуваарийн дагуу хийдэг боловч хөрөнгө оруулалтын асуудлаас болоод шугам сүлжээг богино хугацаанд шинэчилж чаддаггүй. Харин 2018 оноос эхлэн цэвэр усны шугам сүлжээг засварлах, шинэчлэх ажилд шуудуу ухалгүйгээр шугам хоолой доторлох технологийг нэвтрүүлж, үйл ажиллагаа явуулж байна. Замын хөдөлгөөнийг хаахгүйгээр богино хугацаанд хийдэг, зардал болон нөхөн сэргээлтийн ажил бага гээд давуу талтай. Энэхүү шугам доторлогооны ажлыг Австри улсын “Ар Ти Ай” компанитай гэрээ

байгуулж, Австри, Монгол Улсын хоорондын хөнгөлөлттэй зээлээр машин механизм, багаж хэрэгслэл, материал тоног төхөөрөмжийг авч ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар голдуу нягтрал хөдөлгөөн ихтэй, насжилт өндөр 8.5 км шугам сүлжээг доторлосон. Шугам сүлжээг сүвлэн доторлох хоёр төрлийн технологи ашиглаж байна. CIPP буюу давирхайн цавуутай давуун материалаар шугам доторлох технологийг өнгөрсөн 10 дугаар сард бид өөрсдөө бие дааж туршлаа. Туршилтын ажилд зөвхөн монгол инженер, ажилчид оролцсоноороо онцлогтой. Нэг талаар түүхэн үйл явдал гэж бодож байна...”

Эх сурвалж: БХБЯ Барилгын хөгжлийн төв

БНЧУ-ЫН ЭЛЧИН САЙД ИЙРЖИ БРОДСКИ ОЙН МЕНЕЖМЕНТ, УС, ОРЧНЫ БОХИРДЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХОЁР ТАЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛНЭ ГЭДЭГТ ИТГЭЖ БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЛЭЭ



БОАЖ-ын сайд Н.Уртнасан 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Бүгд Найрамдах Чех улсын Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ийржи Бродскийн санаачилгаар цахим уулзалт хийжээ. Уулзалтаар талууд хоёр орны байгаль орчны салбарын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа зэрлэг амьтдыг хамгаалах, сэргээн нутагшуулах, ойн менежментийг сайжруулах, ус, агаар орчны бохирдол болон аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа зэрэг олон талт сэдвээр санал солилцсон байна. БНЧУ-ын Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ийржи Бродски энэ үеэр хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд ойн менежмент, ус, орчны бохирдлын чиглэлээр талууд цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлжээ. БОАЖ-ын сайд Н.Уртнасан хариуд нь хоёр орны байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа болон цаашид авч хэрэгжүүлэх бүх ажлыг дэмжин ажиллана гэдгээ хэлсэн байна.

сурвалж: БОАЖЯ

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн ээлжит хуралдаан 2021 оны 2 дугаар сарын 8-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, хэд хэдэн асуудал авч хэлэлцсэний дунд Усны барилга байгууламжийн буурь /БНБД 33-04-09/ шинэчлэх асуудал багтжээ. Эх сурвалж: БХБЯ
- Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд олон нийтийн оролцоог хангах үүднээс мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны академи, их дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачдад төлөвлөлтийн талаарх мэдээлэл өгөх, тэдний санал, зөвлөмжийг авах, тусгах зорилгоор үе шаттай хэлэлцүүлгүүдийг цахимаар зохион байгуулах гэж байгаа бөгөөд эхний үе шатны хэлэлцүүлгийг 2021 оны 2 дугаар сарын 24-нөөс 3 дугаар сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулахаар төлөвлөжээ. Эх сурвалж: Хотмил үйл үйлдвэр судалгааны институт